

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хог хаягдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3, 21 дүгээр зүйлийн 21.2, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгоход шаардагдах санхүүжилтийг жил бүр улсын төсөвт тусган, Байгаль хамгаалах сангаас санхүүжүүлж байхыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Сангийн сайд Ч.Улаан нарт зөвшөөрсүгэй.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюунд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч. САЙХАНБИЛЭГ

Байгаль орчин, ногоон
хөгжлийн сайд

Д.ОЮНХОРОЛ

Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, суртчилах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хаягдалгүй техник, технологи нэвтрүүлсэн, хог хаягдлаа бууруулсан, хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгахад шинэлэг менежментийг нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага урамшуулалд хамрагдах болон урамшуулал олгоход оролцогч талууд тус журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Урамшуулах үйл ажиллагааны чиглэл, шалгуур үзүүлэлт

2.1. Хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны чиглэл, түүнд тавих шаардлага:

- 2.1.1. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаанд хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй, зардал хэмнэсэн аргачлал, зохион байгуулалтыг нэвтрүүлэх;
- 2.1.2. Үйлдвэрлэл, үйлчилгээнээс үүсэх хог хаягдлыг бууруулах оновчтой санал, санаачлага боловсруулж хэрэгжүүлэх;
- 2.1.3. Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах талаар иргэд, олон нийтийн ухамсрыг дээшлүүлэх, боловсрол олгох шинэлэг, санал санаачлага, арга зүй боловсруулан туршиж эерэг үр дүнд хүрэх;
- 2.1.4. Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах нэвтрүүлэг, сурталчилгаа хийж хүүхэд, олон нийтэд зөв төлөвшил ухамсар суухад нөлөө үзүүлэх
- 2.1.5. Хог хаягдлыг ангилан ялгах оновчтой аргачлал, санаачлага гаргаж дэлгэрүүлэх;
- 2.1.6. Төв суурин газраас алслагдсан айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага болон аялал жуулчлалын бүс, тусгай хамгаалалтай газар нутаг, овоо тахилга зэрэг зам дагуух хог хаягдлын хуримтлал бий болдог газар нутагт хог хаягдлын оновчтой менежмент нэвтрүүлэх;

2.2. Хэмнэлттэй, хаягдалгүй технологийн чиглэл, түүнд тавих шаардлага:

- 2.2.1. Үйлдвэрлэлийн явцад түүхий эдийн ашиглалтыг нэмэгдүүлсэн техник, технологи нэвтрүүлсэн байх;
- 2.2.2. Хог хаягдлаас үүсэх орчны бохирдлыг бууруулах техник, технологи, бүтээгдэхүүн нэвтрүүлсэн байх;

Төсөл

- 2.3. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах үйл ажиллагааны чиглэл, түүнд тавих шаардлага:
 - 2.3.1. Хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй аргаар цуглуулах, хадгалах зориулалт бүхий хэрэглээний шаардлага хангасан сав, байгууламжийн зураг шинээр боловсруулж, үйлдвэрлэсэн байх
 - 2.3.2. Өөрийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний үр дүнд болон дам нөлөөгөөр бий болдог хог хаягдлыг цуглуулах, дахин ашиглах, дараагийн шатны боловсруулалтад нийлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах
- 2.4. Хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах үйл ажиллагааны чиглэл, түүнд тавигдах шаардлага:
 - 2.4.1. Хог хаягдлаар стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байх;
 - 2.4.2. Хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах ажил, үйлчилгээ эрхэлсэн байх;
 - 2.4.3. Хог хаягдал ашиглан хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй аргаар эрчим хүч, дулаан үйлдвэрлэсэн байх;

Гурав. Урамшуулалд хамрагдах этгээдэд тавих шалгуур үзүүлэлт

- 3.1. Урамшуулалд хамрагдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь дараах ерөнхий шалгуур үзүүлэлтүүдийг нэгэн зэрэг, түүнчлэн холбогдох үйл ажиллагааны чиглэлийн нэмэлт шалгуур үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.
- 3.2. Ерөнхий шалгуур үзүүлэлт:
 - 3.2.1. Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллага байх;
 - 3.2.2. Тогтмол, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байх;
 - 3.2.3. Хуулиар ногдуулсан татварыг хугацаанд нь бүрэн төлж, тайлагнадаг байх;
 - 3.2.4. Хог хаягдлын нэгдсэн болон анхан шатны мэдээллийн санд бүртгүүлсэн байх;
 - 3.2.5. Хог хаягдлын нэгдсэн болон анхан шатны мэдээллийн санд холбогдох мэдээ, тайлангаа тогтоосон хугацаанд гаргаж өгдөг байх;
 - 3.2.6. Эрхэлж буй үйлдвэрлэл, үйлчилгээндээ байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн байх;
 - 3.2.7. Журмын 2.1.4, 2.3.1-д заасан үйл ажиллагааны чиглэлд ерөнхий шалгуур үзүүлэлтийн 3.2.3 -3.2.5-д заасан заалт үйлчлэхгүй.
 - 3.2.8. Урамшуулалд хамрагдах үйл ажиллагааны үр дүн нь харьцуулж болохуйц, тоон үзүүлэлт нь чанарын ялгааг илэрхийлэхүйц байх;

Төсөл

3.2.9. Иргэнд урамшуулал олгоход дээрх бүх шаардлагаас зөвхөн 3.2.8-д заасан шалгуур үзүүлэлт хангагдсан байна. Тухайн иргэн нь байнгын оршин суух хаяг, бүртгэлтэй, хог хаягдал, орчны бохирдол буурсан үр дүн гарсан баг, хорооны иргэд үр дүнг батламжилж тодорхойлолт гарган тухайн шатны Засаг даргаар дэмжүүлсэн байна;

3.3. Нэмэлт шалгуур үзүүлэлт:

3.3.1. Энэ журмын 2-т заасан зарим үйл ажиллагаанд ерөнхий шалгуур үзүүлэлтээс гадна дараах нэмэлт шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

3.3.2. Хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны хувьд:

- 1) Энэ журмын 2.1.1, 2.1.3 - 2.1.6-д заасан үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн ухамсар, боловсролыг дээшлүүлсэн нь судалгаагаар, үр дүн нь олон нийтийн санал асуулгаар тогтоогдсон байх.

3.3.3. Хэмнэлттэй, хаягдалгүй технологийн хувьд:

- 1) Үйлдвэрлэл, үйлчилгээндээ нөөцийг иж бүрэн, хаягдалгүй ашигладаг технологи нэвтрүүлсэн байх;
- 2) Үйлдвэрлэл, үйлчилгээний дамжлага бүрт үүсч болох бохирдол, хаягдал /шингэн, хий, хатуу/-ыг бууруулсан байх;
- 3) Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн техник, технологитой байх.

3.3.4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах үйл ажиллагааны хувьд:

- 1) Зориулалтын стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгсэл, сав баглаа боодлыг үйлчилгээндээ ашигладаг байх;
- 2) Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг үйлчилгээндээ нэвтрүүлсэн байх;
- 3) Тээвэрлэгчийн хариуцсан нутаг дэвсгэрт ил задгай, бөөгнөрсөн хог хаягдалгүй байх.

3.3.5. Хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах үйл ажиллагааны хувьд:

- 1) Дахин боловсруулах, эргүүлэн ашиглах технологи нь хүний эрүүл, мэнд байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх;
- 2) Техник, технологи нь стандартын шаардлага хангасан, үр ашигтай байх;
- 3) Дахин боловсруулах, эргүүлэн ашиглах замаар гаргаж авсан бүтээгдэхүүн нь хэрэглээнд үндэслэсэн, стандартын шаардлага хангасан, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй нь лабораторийн холбогдох шинжилгээгээр баталгаажсан байх

3.3.6. Хог хаягдлыг устгах үйл ажиллагааны хувьд:

- 1) Хаягдал устгах үйл ажиллагаа эрхлэх зориулалтын байгууламжтай байх;
- 2) Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар технологитой байх

Дөрөв. Урамшууллын хэлбэр, хэмжээ

4.1. Урамшууллын журмын 5.5.2-т заасан ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн, Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дор дурдсан журмын дагуу шийдвэр гаргаж, шалгарсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгоно.

4.1.1. –Тоног

4.1.1. Шалгарсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бараа, бүтээгдэхүүн, үйл ажиллагаанд “Ногоон” гэрчилгээ, “Эко” тэмдэг олгоно. Гэрчилгээ нь дараах тө

4.1.2. “Ногоон” гэрчилгээ, “Эко” тэмдгийг авсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

4.1.3. Дээрх гэрчилгээ, тэмдгийг мөнгөн урамшуулал дагалдана.

4.1.4. “Ногоон” гэрчилгээ, “Эко” тэмдэг авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь “Эко” тэмдгийг өөрийн бараа бүтээгдэхүүн, тээврийн хэрэгсэл зэрэгт ашиглаж болно.

4.1.5. Хэрэв “Эко” тэмдэг ашиглаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь тус журмын 6 дугаар зүйлд заасан нөхцөл байдалд хүрсний улмаас “Эко” тэмдэг ашиглах эрхээ хасуулсан тохиолдолд өөрийн бүтээгдэхүүн, тээврийн хэрэгсэлд цаашид уг тэмдгийг ашиглахгүй байх арга хэмжээг даруй авч хэрэгжүүлнэ.

4.1.6. “Эко” тэмдгийн хэлбэр, загвар дизайн, өнгө, хэрэглэх аргачлал зэргийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.1.7. Тухайн “Эко” тэмдэг, “ногоон” гэрчилгээ нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өмч байна.

4.2. Мөнгөн урамшууллын эх үүсвэр ба хэмжээ

4.2.1. Урамшуулалд шаардагдах хөрөнгийг жил бүр Байгаль хамгаалах сангийн төлөвлөгөөнд тусгаж, санхүүжүүлнэ.

4.2.2. Нийт санхүүжилтийн 40 хувийг журмын 2.1-т заасан “хог хаягдлын менежмент сайжруулах үйл ажиллагааны чиглэл”-д, 2.2-2.4-т заасан “хэмнэлттэй хаягдалгүй технологийн чиглэл”, “хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах үйл ажиллагааны чиглэл”, “хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах үйл ажиллагааны чиглэл”-үүдэд тус бүр 20 хувийг хуваарилна.

4.2.3. Эцсийн шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсэг хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны чиглэлүүдэд олгох мөнгөн урамшууллын хувь хэмжээг 4.2.2-т заасан хуваарьт багтаан хамрагдсан этгээдийн тоо, тэдгээрийн үйл ажиллагааны далайц, ач холбогдол, хүрсэн үр дүн, тоо хэмжээг харгалзан 5.5-д заалтаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлаар тогтооно.

Тав. Урамшуулал олгох үйл ажиллагааг зохион байгуулах

Төсөл

5.1. Урамшууллыг жилд нэг удаа Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгоно.

5.2. Урамшууллыг үйл ажиллагааны чиглэл тус бүрээр сонгон шалгаруулж, шалгарсан этгээдэд урамшуулал олгоно.

5.3. Сонгон шалгаруулалтыг анхан болон эцсийн гэсэн хоёр үе шаттай явуулна.

5.4. Анхан шатны сонгон шалгаруулалт

5.4.1. Анхан шатны сонгон шалгаруулалтыг аймаг, дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг даргын баталсан ажлын хэсэг зохион байгуулна.

5.4.2. Тус ажлын хэсэг нь аж ахуйн нэгж хариуцсан татварын улсын байцаагч, хог хаягдлын дунд шатны мэдээллийн сангийн ажилтан, орчны бохирдол, байгаль орчны хяналтын улсын байцаагч, мэргэжлийн байгууллага, иргэдийн төлөөллөөс бүрдсэн 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

5.4.3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд сонгон шалгаруулалтад нэр дэвшиж байгаа иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл болон тэдэнтэй ашиг сонирхол нэгтэй этгээдийг оруулахгүй.

5.4.3. Ажлын хэсгийн ажиллах болон сонгон шалгаруулалтыг зохион байгуулах удирдамжийг энэхүү журамд нийцүүлэн боловсруулж, тухайн шатны Засаг дарга батална.

5.4.4. Ажлын хэсгийг жил бүр шинэчлэн зохион байгуулж болох бөгөөд өмнөх ажлын хэсгийн 2/3-ийг хэвээр хадгалж үлдээнэ.

5.4.5. Сонгон шалгаруулалттай холбогдох ажлын хэсэг байгуулах, сонгон шалгаруулалтыг зарлан мэдээллэх, материалыг хүлээн авах, ажлын хэсгийн хурлыг зохион байгуулах, холбогдох мэдээ материалыг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх зэрэг үйл ажиллагааг орон нутгийн байгаль орчны асуудал хариуцсан нэгж зохион байгуулна.

5.4.6. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, олон улсын байгууллагын зээл, тусламжаар байгуулсан үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага нь журмын 2.1-д зааснаас бусад чиглэлээр урамшуулалд хамрагдахаар нэр дэвшихгүй.

5.4.7. Хэрэв 5.4.6-д заасан аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн аж ахуйн үйл ажиллагааны үндсэн дээр бий болсон хөрөнгийг ашиглан 2.2, 2.3, 2.4-т заасан нөхцлийг хангаснаа санхүүгийн бүртгэлийн баримтаар нотлосон тохиолдолд тухайн чиглэлд нэр дэвших боломжтой.

5.4.8. Сонгон шалгаруулалтын уралдааныг 1 сараас доошгүй хугацаанд нээлттэй, олон нийтэд зарлаж, тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд оролцох тэгш боломжоор хангана.

Төсөл

5.4.9. Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтыг энэ журамд заасан үйл ажиллагааны чиглэл тус бүр дээр зөвхөн тухайн чиглэлд тавигдсан ерөнхий болон нэмэлт шалгуур үзүүлэлт хангасан иргэн, аж ахуйн нэгжийг сонгох ба олонхийн саналаар шийдвэрлэж, дүгнэлт гаргана.

5.4.10. Сонгон шалгаруулалтын тайлан болон шалгарсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын материалыг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.4.11. Тогтоосон хугацаанаас хоцорсон материалыг эцсийн шатны сонгон шалгаруулалтад оруулахгүй.

5.5.Эцсийн шатны сонгон шалгаруулалт

5.5.1.Эцсийн шатны сонгон шалгаруулалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ажлын хэсэг зохион байгуулна.

5.5.2. Тус ажлын хэсэг нь байгаль орчин, эрүүл мэнд, үйлдвэр, хөдөө аж ахуйн, зам тээвэр, барилга байгууламж, уул уурхай, боловсролын салбар болон хэвлэл мэдээлэл, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

5.5.3. Анхан шатны шалгаруулалтын материалыг хүлээн авах, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулах, ажлын хэсгийн хурлыг зохион байгуулах, холбогдох мэдээ материалыг бэлтгэх ажлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн төв байгууллагын хог хаягдлын асуудал хариуцсан мэргэжилтэн зохион байгуулна.

5.5.4. Ажлын хэсэг нь аймаг, дүүргүүдээс ирсэн тайлан, материалуудыг судлан дүгнэлт гаргана.

5.5.5. Урамшуулалд хамрагдаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг 12 сарын 14-ны дотор сонгон шалгаруулж нийтэд мэдээлнэ.

Зургаа. Урамшууллын өргөмжлөл, тэмдгийг буцаан авах

6.1. Анхан шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан ажлын хэсэг нь шалгарч “Ногоон” гэрчилгээ, “Эко” тэмдэг авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын цаашдын үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, тухайн гэрчилгээ, тэмдгийг авсан чиглэлээрээ үйл ажиллагаагаа зогсоосон, шалгуур үзүүлэлтийг хангасан түвшингээсээ бууруулсан тохиолдолд гэрчилгээ, тэмдгийг хураан авах саналыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6.2. Анхан шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан ажлын хэсэг нь “Ногоон” гэрчилгээ, “Эко” тэмдэг авсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа нь тухайн тэмдгийн зорилго, зорилтыг хангахаар түвшинд байгаа талаар иргэд, олон нийтийн мэдээлэлд үндэслэн хяналт тавьж, ажлын хэсгийн дүгнэлт, холбогдох нотолгооны хамт

Төсөл

эцсийн шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсэгт жилд нэг удаа 11 сарын 25-ны дотор ирүүлнэ.

6.3. Эцсийн шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсэг нь 6.1-т заасан саналыг үндэслэн “Ногоон” гэрчилгээ, “Эко” тэмдгийг хураан авах эсэх талаар дүгнэлт гаргаж, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

6.4. Уг гарсан шийдвэрийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхээс гадна мэдээлэл өгсөн, гомдол гаргасан иргэнд хариуг бичгээр мэдэгдэнэ.

Долоо. Бусад зүйл

7.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь урамшуулал олгох хэд хэдэн үйл ажиллагааны чиглэлд нэр дэвшиж болох ба нэр дэвшиж байгаа үйл ажиллагааны чиглэл тус бүрээр шалгуур үзүүлэлтийг хангасан материал ирүүлнэ.

7.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгжүүлж үр дүнд хүрсэн нэг үйл ажиллагааны чиглэлд зөвхөн нэг удаа урамшуулал олгоно.

7.3. Өмнөх жил нь урамшуулалд нэр дэвшиж шалгараагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа тохиолдолд дахин нэр дэвшиж болно.

-----oOo-----